**ОРХОН АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН**
# ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 08-ны өдөр Дугаар А/46 Эрдэнэт

"Өлсөглөн зарлагч иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тухай"

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дах заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.2 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын "Өлсгөлөнгийн үед эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх тухай" 2010 оны 233 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өлсгөлөн зарлагчийн эрүүл мэндэд үзлэг хийх, хяналт тавих багийн бүрэлдэхүүнийг 1-р хавсралтаар, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэл, хуваарийг 2-р хавсралтаар тус тус батласугай.

2. Өлсгөлөн зарлагч иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг шуурхай үзүүлж, мэдээллээр хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Эх хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн / П.Хишгээ/-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилэн / Г.Энхжаргал /-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.СҮХЭЭ

My doc. EMG-iin dargiin tushaal

Эрүүл мэндийн газрын даргын
2021 оны 05 дугээр сарын
18...-ний өдрийн [illegible] дугаар
нэгдүгээр тушаалын хавсралт

Өлсгөлөн зарлагчийн эрүүл мэндэд үзлэг хийх, хяналт тавих
багийн бүрэлдэхүүн

| № | Бүрэлдэхүүн | Нэр | Чиглэл |
|---|---|---|---|
| 1 | Ахлагч | П.Хишгээ | ЭМГ-ын Эх хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн |
| 2 | Мэргэжлийн эмч нарын баг | Б.Одонтунгалаг | БОЭТ-ийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга |
| 3 | Итгэмжлэгдсэн эмч | Б.Мөнгөнчимэг | БОЭТ-ийн Хөнгөвчлөх, уламжлалын тасгийн эрхлэгч |
| 4 | Дотор, дотоод шүүрэл | М.Энхтуяа | БОЭТ-ийн Дотрын тасгийн эрхлэгч |
| 5 | Зүрх судас | А.Ундрах | БОЭТ-ийн зүрх судасны эмч |
| 6 | Мэдрэл | Б.Даваасүрэн | БОЭТ-ийн мэдрэлийн тасгийн эрхлэгч |
| 7 | Мэс засал | Л.Тунгалагтамир | БОЭТ-ийн Поликлиникийн эрхлэгч |
| 8 | Сэтгэц | Л.Будсүрэн | БОЭТ-ийн Сэтгэцийн тасгийн эрхлэгч |
| 9 | Шинжилгээ авах, сувилахуйн тусламж үйлчилгээ | М.Батдулам | БОЭТ-ийн ЭЭ-ний тасгийн арга зүйч |
| 10 | Шинжилгээ авах, сувилахуйн тусламж үйлчилгээ | Л.Очирмаа | БОЭТ-ийн дотрын тасгийн арга зүйч |

Эрүүл мэндийн газрын даргын
2021 оны 05 дугээр сарын
.08.-ний өдрийн А/46.дугаар
хоёрдугаар тушаалын хавсралт

## Өлсгөлөн зарлагч иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэл, хуваарь

| № | Үйл ажиллагаа | Хугацаа | Хариуцах эзэн | Чиглэл |
|---|---|---|---|---|
| 1 | Эрүүл мэндийн иж бүрэн үзлэгт хамруулах | 2021.05.08 | Мэргэжлийн эмч,сувилагч нарын баг | -Хэмжилт хийх /биеийн халуун, жин, өндөр, цусны даралт, судасны цохилт, амьсгалын тоо, захын цусанд хүчилтөрөгчийн ханамж үзэх/<br>-Нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг хийх, үзлэгийн хуудаст тусгах<br>-Шинжилгээнд хамруулах<br>• Цусны ерөнхий шинжилгээ<br>• Шээсний шинжилгээ<br>• Биохими шинжилгээ<br>/уураг, эрдсүүд, элэгний үйл ажиллагаа,сахар/<br>• Ковид-19-ын шинжилгээнд хамруулах<br>• Бургуй тавих<br>-Өлсгөлөн зарлахад харшлах өвчнийг тогтоох<br>-Өдөр тутмын үзлэг, байнгын хяналт хийх<br>-Ковидын шинж тэмдэг<br>-Өдөр тутмын эрүүл мэндийн дүгнэлт гаргах ,танилцуулах<br>-Эрүүл мэндийн нэгдсэн дүгнэлт гаргах,хурлын тэмдэглэлийн хавсаргах |
| 2 | Эрүүл мэндийн суурь үнэлгээ, эрүүл мэндийн санал дүгнэлтийг дээд шатны байгууллагад хүргүүлэх | 2021.05.08-аас эхлэн өдөр бүр | П.Хишгээ<br>Б.Одонтунгалаг | |
| 3 | Өдөр бүр эрүүл мэндийн байдалд хяналт тавих, мэдээлэх | 2021.05.08-аас эхлэн өдөр бүр | Б.Мөнгөнчимэг | |
| 4 | Өлсгөлөнд оролцогчдод өлсгөлөнгийн хор уршиг, үр дагаварын талаар таниулж, эрүүл ахуй ,халдвар хамгааллын дэглэмийн талаар зөвлөгөө өгөх | 2021.05.08-аас эхлэн өдөр бүр | Б.Мөнгөнчимэг | |
| 5 | Олон улсын хэмжээнд мөрддөг эрт сэрэмжлүүлэх үнэлэмжийн дагуу үнэлгээ хийх | 2021.05.08-аас эхлэн өдөр бүр | Б.Мөнгөнчимэг | |
| 6 | Биеийн эрүүл мэндийн байдал хүндэрч амь насанд ноцтой аюул үүсвэл өлсгөлөнг зогсоож албадан эмчилгээнд оруулах | 2021.05.08-аас эхлэн өдөр бүр | Б.Мөнгөнчимэг | |
| 7 | Яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангах /автомашин/ | 2021.05. 08-наас эхлэн өдөр бүр | Б.Одонтунгалаг | |